



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 324

Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан
журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-д дор дурьдсан агуулгатай 2.6, 2.7, 2.8, 2.9 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ “2.6. Даатгалын компанийн салбар нь дараах мэдээллийг Хороонд ирүүлнэ:

2.6.1. “Хөрөнгө, өр төлбөр, орлого, нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг 30 дугаар хавсралтаар” гэснийг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар;

2.6.2. “Орлого, нөхөн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг 31 дүгээр хавсралтаар” гэснийг энэ тогтоолын 2 дугаар хавсралтаар;

2/ 2.7. Энэ журмын 2.6-д заасан хавсралтуудыг харьяалагдах аймаг, нийслэл, дүүрэг, орон нутгийн төлөөлөгчид хүргүүлнэ. Хорооны орон нутгийн төлөөлөгч нь тухайн орон нутаг дахь даатгалын байгууллагын салбарын тайланг нэгтгэж, зайны хяналтын тайланг хагас жилээр гаргаж, жил бүрийн 3 дугаар сарын 1, 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор тус тус Хорооны Даатгалын газарт ирүүлнэ.

3/ 2.8. Даатгалын байгууллага нь даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, даатгуулагчийн тоо, даатгалын гэрээний тоотой холбогдсон мэдээллийг сар бүрийн 10-ны

001398

өдрийн дотор Хорооны Даатгалын газраас хүргүүлсэн цахим маягтаар гарган Хороонд ирүүлнэ.


4/ 2.9. Даатгалын байгууллагын салбар нь салбарын санхүүгийн тайланг гаргаж, энэ журмын 1.2-д заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны аймаг, нийслэл, дүүрэг дэх орон нутгийн төлөөлөгчид хүргүүлнэ.”

2. Уг журмын 26 дугаар хавсралтыг энэ тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу өөрчилсүгэй.

3. Нэмэлт өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, хэлбэрийн заавар” батлах тухай 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Журамд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хөрооны
2012 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр
324 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн
санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга,
маягтыг тогтоох журам “-ын 30 дугаар хавсралт

/төгрөгөөр/

№	Санхүүгийн тайлангийн үзүүлэлт	Мөрийн дугаар		
			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгөн хөрөнгийн дүн	1		
2	Авлага	2		
3	Бараа материал	3		
4	Үндсэн хөрөнгө	4		
4.1	Бусад хөрөнгө	5		
	Нийт хөрөнгийн дүн	6		
5	Нөөц сан	7		
6	Богино хугацаат өглөг	8		
7	Эзэмшигчдийн өмч	9		
8	Ашиг алдагдал	10		
	Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	11		
	Орлого үр дүнгийн үзүүлэлт	12		
9	Хураамжийн орлого	13		
10	Буцаасан даатгал	14		
11	Цэвэр даатгалын хураамж	15		
12	Хохиролд олгосон нөхөн төлбөр	16		
13	Байгуулсан нөөц сан /Хэрэв нөөц байгуулдаг бол/	17		
14	Үндсэн үйл ажиллагааны зардал	18		
15	Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	19		
16	Үндсэн үйл ажиллагааны бус орлого	20		
17	Үндсэн үйл ажиллагааны бус зардал	21		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	22		
19	Орлогын албан татвар	23		
20	Цэвэр ашиг	24		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн
агуулга, маягтыг тогтоох журам “-ын 26 дугаар хавсралт

/төгрөгөөр/

№	Салбарын нэр	Мөрийн дугаар	Зуучилсан даатгалын үнэлгээний хэмжээ	Зуучилсан даатгалын хураамжийн дүн	Даатгалын зуучлалын орлого	Зуучилсан даатгалын гэрээний тоо	Ажиллагчдын тоо
А	Б	В	1	2	3		
1	Төв компани	1					
2	Салбар - 1	2					
3	Салбар - 2	3					
4	...	4					
5	...	5					
6	...	6					
7		7					
8		8					
9		9					
10		10					
11		11					
12		12					
13		13					
14		14					
15		15					
16		16					
		...					
...		...					
	Дүн		Дүн=27 дугаар хавсралтын мөр 18 багана 1	Дүн=27 дугаар хавсралтын мөр 18 багана 2	Дүн=27 дугаар хавсралтын мөр 18 багана 3		

“Ажиллагч” гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоон хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл бүхий банкны хувьд өмнөх тодорхойлолтын хүрээнд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд оролцож буй банкны ажилтанг ажиллагчид хамааруулна.